

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАЛАЛГҮЙ ХҮНД ОРШИН СУУХ,  
ХАРЬЯАЛАЛГҮЙ ХҮНД ЗОРЧИХ ҮНЭМЛЭХ ОЛГОХ,  
ТЭДГЭЭРИЙГ ЭЗЭМШИХ, ХАДГАЛАХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Албан болон хувийн хэргээр Монгол Улсад оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад оршин суух үнэмлэх /цаашид "Оршин суух үнэмлэх" гэх/, харьяалалгүй хүний гадаад улсад зорчих үнэмлэх /цаашид "Зорчих үнэмлэх" гэх/ хэвлэх, олгох, эзэмших, хадгалах, ашиглахад энэхүү журмыг баримтална.

1.2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэх хэвлэх, олгох, солих, хураан авах, хүчингүй болгох, дахин олгох, харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох, хураан авах, хүчингүй болгох, эдгээр үнэмлэхийн нэгдсэн бүртгэл хөтлөх үйл ажиллагааг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "Газар" гэх/ эрхэлнэ.

Хоёр.Оршин суух үнэмлэх хэвлэх, олгох

2.1. Газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасан мэдээллийг тусгасан оршин суух үнэмлэхийг хэвлэн нэгдсэн бүртгэл хөтлөнө.

2.2. Гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хугацаагаар оршин суух үнэмлэхний хугацаа тодорхойлогдоно.

Гурав.Оршин суух үнэмлэхийг дахин олгох

3.1.Оршин суух үнэмлэхийг дараах тохиолдолд дахин олгоно:

3.1.1.паспорт солигдсон;

3.1.2.оршин суух үнэмлэхээ гэсэн, үрэгдүүлсэн;

3.1.3.оршин суух үнэмлэхийн хүчинтэй байдлыг алдагдуулсан;

3.1.4.дүр төрхөд өөрчлөлт орсон;

3.1.5.уригч байгууллага солигдсон;

3.1.6.овог, нэр, хүйс, төрсөн огноо өөрчлөгдсөн;

3.1.7.оршин суух зөвшөөрлийн хэлбэр, төрөл өөрчлөгдсөн, хугацаа дууссан.

3.2.Оршин суух үнэмлэхийг дахин олгож өгөх тухай хүсэлт гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

3.2.1.паспорт;

3.2.2.оршин суух үнэмлэх дахин олгож өгөхийг хүссэн албан бичиг /хувь хүн бол өргөдөл/;

3.2.3.оршин суух үнэмлэхээ гэсэн, үрэгдүүлсэн болохыг зарлуулсан тухай баримт болон цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн тодорхойлолт;

3.2.4.тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт.

3.3.Гадаадын иргэн энэ журмын 3.1-д заасан үндэслэлээр 3.2-т заасан баримт бичгийг бүрдүүлж өгснөөс хойш ажлын 5 өдөрт багтаан оршин суух үнэмлэх дахин олгоно.

Дөрөв.Оршин суух үнэмлэхийг хураах, хүчингүй болгох

4.1.Оршин суух үнэмлэх авсан гадаадын иргэн Монгол Улсын харьяат болсон тохиолдолд Ерөнхийлөгчийн зарлиг гарснаас хойш 30 хоногийн дотор оршин суух үнэмлэхийг Газарт хураалгаж, тодорхойлолт авна.

4.2.Оршин суух үнэмлэхийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

4.2.1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 28 дугаар зүйлийн 28.4, 29 дүгээр зүйлийн 29.3-т заасан үндэслэл байгаа бол;

4.2.2. оршин суух үнэмлэхний хугацаа дууссан, хасалт хийгдсэн бол.

4.3. Газарт хураагдсан оршин суух үнэмлэхийн баруун доод буланг хайчлан хүчингүй болгоно.

Тав.Оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах

5.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасны дагуу гадаадын иргэн нь оршин суух үнэмлэхээ биедээ байнга авч явах үүрэгтэй бөгөөд Газарт хураалгаснаас бусад тохиолдолд эзэмшигч өөрөө хадгална.

5.2.Оршин суух үнэмлэхийг бусдад шилжүүлж, барьцаалж үл болно.

5.3.Гадаадын иргэн Монгол Улсаас бүр мөсөн, эсхүл оршин суух зөвшөөрлийн хугацаанд ирэхгүйгээр явах бол оршин суух үнэмлэхээ Газарт хураалгаж, хасалт хийлгэнэ.

5.4. Нас барсан гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг хүчингүй болгож, гэр бүлийн гишүүнд хадгалуулахаар өгч болно.

5.5. Гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн лавлагааг цахим хэлбэрээр олгож болох бөгөөд энэ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхний нэгэн адил хүчинтэй байна.

5.6. Цахим хэлбэрээр олгох лавлагааны загварыг Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны дарга батлана.

5.7. Энэ журмын 5.5-д заасан цахим лавлагаатай тохиолдолд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасан үүргээ биелүүлсэнд тооцно.

5.8. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч хяналт шалгалтын явцад оршин суух үнэмлэхийг эх хувиар нь шаардаж болно.

### Зургаа.Зорчих үнэмлэх олгох

6.1.Монгол Улсад оршин суугаа харьяалалгүй хүн Газраас олгосон зорчих үнэмлэхээр гадаад улсад зорчино.

6.2.Зорчих үнэмлэхийг дараах хүнд олгоно:

6.2.1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа харьяалалгүй хүнд;

6.2.2.гадаад улсын харьяат болох зорилгоор Монгол Улсын харьяатаас гарсан боловч өөр улсын харьяат болоогүй хүн гадаад улсад зорчих бол.

6.3.Зорчих үнэмлэхэд Газрын дарга, эсхүл түүний эрх олгосон албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

6.4.Зорчих үнэмлэх авах хүсэлтийг Газарт хандаж гаргах бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

6.4.1.өргөдөл;

6.4.2.оршин суух үнэмлэх;

6.4.3.3.5x4.5 см хэмжээтэй 2 хувь цээж зураг.

6.4.4.гадаад улсын харьяалалгүй тухай холбогдох байгууллагын лавлагаа

6.5.Энэ журмын 6.4-т заасан баримт бичгийг хүлээн авсан албан хаагч дор дурдсан зүйлийг нягтална:

6.5.1.энэ журмын 6.2.1-д заасан харьяалалгүй хүний хувьд Монгол Улсад оршин суух үнэмлэх, урьд нь харьяалагдаж байсан улсынхаа харьяатаас гарсныг гэрчлэх баримт;

6.5.2.Энэ журмын 6.2.2-т заасан харьяалалгүй хүний хувьд Монгол Улсын харьяатаас гарах хүсэлтэд мэдүүлсэн улсын харьяалалтай болсон эсэх;

6.5.3.хүүхдийн төрсний гэрчилгээ хүчин төгөлдөр эсэх, овог нэр, төрсөн он, сар, өдөр зөв эсэх, өөрийнх нь гэрэл зураг мөн эсэх;

6.5.4.гадаад улсад зорчихыг түдгэлзүүлэх, хойшлуулах үндэслэл байгаа эсэх.

6.6.Хүсэлт гаргагчийн материалыг хүлээн авсан албан хаагч зорчих үнэмлэхийг ажлын 10 өдөрт багтаан олгоно.

#### Долоо.Зорчих үнэмлэхийг дахин олгох

7.1.Зорчих үнэмлэхийн хугацаа дууссан, үрэгдүүлсэн, гэмтээсэн, эсхүл мэс ажилбар хийлгэснээс үнэмлэх эзэмшигчийн царай өөрчлөгдсөн тохиолдолд дараах баримт бичгийг үндэслэн зорчих үнэмлэхийг дахин олгоно:

7.1.1.энэ журмын 6.2.1-д заасан харьяалалгүй хүний хувьд оршин суух үнэмлэх;

7.1.2.зорчих үнэмлэх /хугацаа нь дууссан бол/

7.1.3.3.5x4.5 см хэмжээтэй 1 хувь цээж зураг;

7.1.4.зорчих үнэмлэх дахин олгож өгөхийг хүссэн өргөдөл;

7.1.5.зорчих үнэмлэх үрэгдүүлсэн болохыг зарлуулсан тухай холбогдох баримт болон цагдаагийн байгууллагад бүртгүүлсэн тодорхойлолт;

7.1.6. тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт.

#### Найм.Зорчих үнэмлэх олгохоос татгалзах

8.1.Харьяалалгүй хүний гадаадад зорчих эрхийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн, өөр улсын эрх бүхий байгууллагаас зорчих үнэмлэх олгож байсан тохиолдолд түүнд зорчих үнэмлэх олгохоос татгалзах бөгөөд энэ тухай ажлын 5 өдөрт багтаан бичгээр мэдэгдэнэ.

#### Ес.Зорчих үнэмлэх эзэмших, ашиглах, хадгалах

9.1.Зорчих үнэмлэх эзэмшигч нь Монгол Улсад буцаж ирэхгүй тохиолдолд Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт, буцаж ирсэн тохиолдолд Газарт тус тус зорчих үнэмлэхээ хураалгана.

9.2.Зорчих үнэмлэхийг бусдад шилжүүлж, барьцаалж үл болно..

#### Арав.Зорчих үнэмлэхийг хүчингүй болгох

10.1. Дараах тохиолдолд зорчих үнэмлэхийг хүчингүй болгоно:

10.1.1. гэмтээсэн, засварласан;

10.1.2. бусдад шилжүүлсэн;

10.1.3. хуульд заасан бусад.

10.2. Хүчингүй болсон, гэмтсэн, хүчинтэй хугацаа нь дууссан, түүнчлэн энэ журмын 9.1-д заасны дагуу дипломат төлөөлөгчийн газраас ирүүлсэн зорчих үнэмлэхийг Газар устгана.

10.3. Хүчин төгөлдөр бус, эсхүл зөрчил бүхий зорчих үнэмлэхтэй этгээдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй бөгөөд тухайн үнэмлэхийг хураан авна.

#### Арван нэг. Бусад

11.1. Зорчих үнэмлэх нь олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүчинтэй байна.

11.2. Гадаадын иргэн оршин суух үнэмлэхээ гэмт хэргийн улмаас хаясан, гээгдүүлсэн, алдсан, үрэгдүүлсэн талаар эрх бүхий байгууллагаас тодорхойлолтыг ирүүлсэн тохиолдолд торгох шийтгэл оногдуулахгүйгээр шинээр олгож болно.

11.3. Гадаадын иргэн оршин суух үнэмлэхээ өөрийн буруутай үйлдлээс шалтгаалан үрэгдүүлсэн, хүчинтэй байдлыг нь алдагдуулсан бол Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.